



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/37

Модот

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Нотариатын 2022 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн гэрээг судлан үзээд, Цэрэнгомбо овогтой Лхамдэндэв (СУ30081076)-ийн эзэмшиж буй Цэнхэрмандал сумын 1 дүгээр баг Хужхан, Тойны үзүүрт байрлах, 2321001826 нэгж талбарын дугаартай өвөлжөөний зориулалттай 10000 квадрат метр газар, 1 дүгээр баг Хужхан, Гөөгийн хажууд байрлах 2321001825 нэгж талбарын дугаартай хаваржааны зориулалттай 10000 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Одбаяр овогтой Лувсан (СУ93102611)-д шилжүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар эзэмшил, ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмшигч Одбаяр овогтой Лувсан -д даалгасугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамал (Я.Отгонтуяа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын засаг даргын 2014 оны 08 дугаар сарын 15-ний өдрийн А/84 тоот захирамжын иргэн Ц.Лхамдэндэв-д холбогдох хэсэг эзэмшлийн 000530472, 000530471 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээнүүдийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ- ОРГИЛ